



# СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

208 /208/ 2021.12.24

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

## ЗХЖШ-ЫН ДАРГА ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 353 ДУГААР АНГИД АЖИЛЛАВ

1935 он.

Япон, Манжийн цэрэг манай улсын Булан дэрсний харуулд дахин цэргийн хүчээр довтолжээ.



ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг өнөөдөр Зэвсэгт хүчний 353 дугаар ангид ажиллав. Түүнийг дагалдаж Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр, ЗХЖШ-ын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга хурандаа Д.Номт, АЦК-ийн удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Б.Энхзоргол болон албаны бусад хүмүүс ажилласан юм. Дэслэгч генерал Д.Ганзоригийг тус ангид хүрэлцэн ирэхэд Налайх цэргийн хүрээний хүндэт харуул угтан авсан бөгөөд Налайх цэргийн хүрээний ангиудын захирагч нар байлцсан юм.

Зэвсэгт хүчний 353 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Аюурзана ангийн үйл ажиллагааг танилцуулсан бөгөөд 2021 он тус ангийн хувьд арвин их ажил хөдөлмөр ундарсан, цэргийн сургалт бэлтгэл, бэлэн байдал, соёл хүмүүжлийн ажил тасралтгүй явагдсан өрнүүн жил байсныг дурдав. Тухайлбал, сургалт бэлтгэлийн хүрээнд өнгөрсөн 9 дүгээр сард зохион байгуулагдсан тактик хэзрийн сургуулийн үеэр "нам өндрийн целийг илрүүлэх, радиолокацийн пост дэлгэн

радиолокацийн мэдээгээр хангах ажиллагаа"-г амжилттай явуулсан, Агаарын цэргийн нэгдсэн команд штабын сургуулийн хүрээнд болзошгүй агаарын довтолгооноос нийслэл хот, улсын онц чухал объектыг хамгаалах үүргийг амжилттай хэрэгжүүлсэн аж. Соёл хүмүүжлийн ажлын хүрээнд "Зэвсэгт хүчний тэргүүний ардын авьяастан хамт олон" шалгаруулах тэмцээнд амжилттай оролцож Зэвсэгт хүчний хэмжээнд II дугаар байрт шалгарсан, Ардын армийн Жанжин штабын дарга асан дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит анги болж, нэрэмжит танхимыг гэр бүл, төрөл төрөгсөд, ангийн хамт олны дэмжлэгээр тохижуулсан зэрэг олон ажил арга хэмжээг дурдаж болох юм. Танилцуулгын төгсгөлд ангийн захирагч нэн шаардлагатай мэргэжлийн зарим цэргийн алба хаагчдын мэргэжлийн түвшнийг дээшлүүлж ШУТИС-д магистрын сургуульд суралцуулах санал тавьсныг ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг нааштай хүлээн авсан юм.

Үүний дараа ажлын хэсгийн бүрэлдэхүүн ангийн зарим зэвсэг техниктэй танилцсаны зэрэгцээ

бие бүрэлдэхүүнтэй уулзсан юм. Энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг ангийн бие бүрэлдэхүүнд хандаж хэд хэдэн зарчмуудыг онцлон захисан юм. Тэрээр "Өөрийгөө хөгжүүлэхийг нэн тэргүүнд тавь. Мөн эрүүл мэнд, бие бялдар, эрдэм мэдлэг, сэтгэл зүйгээ бэлтгэ. Хэрэв аль нэг нь хангалтгүй байгаа бол яг өнөөдрөөс бэлтгэж эхэл. Сурахад хэзээ ч оройтдоггүй. Харин оролдлого хийдэггүй хүнд ололт, амжилт холоос хол явдгийг санах хэрэгтэй. Ажлын байран дахь цаг ашиглалтыг дээшлүүлж, хувийн сахилга бат, зохион байгуулалтаа сайжруулах хэрэгтэй байна. Зэвсэгт хүчний хөгжлийн амин сүнс нь бие бүрэлдэхүүний хөгжил, тэдний төлөвлөлт, байгууллагын зөв тогтсон соёлоос шууд хамааралтай юм. Хувь хүн болон байгууллагын хөгжилд бүтээлч сэтгэлгээ хамгаас чухал. Мөрөөдөл тэмүүлэл, өөдрөг сэтгэл, хичээл зүтгэл, тэсвэр тэвчээр, цөхрөлтгүй оролдлого, ажилсаг бүтээлч чадвар энэ бүгд бүтээлч хүнд зайлшгүй байх шилдэг чанар.

Мөн цэргийн бэлтгэл сургалтаа улам төгөлдөржүүл. Сайжруул. Цэрэг хүний үндсэн

хөдөлмөр бол бэлтгэл сургалт бөгөөд энэ хөдөлмөр цэргийн алба хаагчийн хөгжих, мэргэших хэрэгцээг хангахад чиглэгдэх ёстой. Тайван цагт хөлс их асгавал дайны цагт цус бага урсана гэж мэргэн үг байдаг. Байнгын бэлтгэл сургуулилт, сэтгэл зүйн төлөвшил нь ямар ч хүнд сорилтод бэлэн байх чадварыг бий болгохын зэрэгцээ улс орноо батлан хамгаалах үүргээ хариуцлагатайгаар биелүүлэхийн үндсийн үндэс гэдгийг ямагт сана. Бэлтгэл сургалтыг дагаад хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгааг ягштал мөрд. Зөвхөн бэлтгэл сургалтаар хязгаарлагдахгүйгээр өөрийн болон нөхрийнхөө аюулгүй байдлыг үргэлж хамгаал.

Эцэст нь бахархал болсон албаа эрхэмлэж, эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах хүндтэй бөгөөд хариуцлагатай үүрэгтээ их амжилт үзүүлж, чадварыг эрхэмлэсэн үйл ажиллагааг улам бүр идэвхжүүлэн урагшаа тэмүүлэн ажиллахыг уриалъя" гэв. Төгсгөлд нь тэрээр тус ангийн нийт офицер, ахлагч нарт удахгүй тохиох шинэ оны мэнд дэвшүүлж, эрүүл энх, амжилт бүтээлийн дээдийг хүслээ.

### ЦАГ АГААР

#### УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| -18  | -37  |

#### ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|------|------|
| 37   | 24   |

### ВАЛЮТЫН ХАНШ

| ВАЛЮТ | АВАХ    | ЗАРАХ   |
|-------|---------|---------|
| USD   | 2,844.0 | 2,851.0 |
| EUR   | 3,171.0 | 3,242.0 |
| CNY   | 444.30  | 447.70  |
| RUB   | 37.60   | 39.10   |
| JPY   | 24.77   | 25.36   |
| KRW   | 2.36    | 2.45    |

### ЗУРХАЙ

2021.12.24 БААСАН ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 20/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН МОРЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өлсөж ундаасна

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.40-17.03

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал:

Мод

Энэ өдөр нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмт хэрэг илрүүлэх, гэм буруутныг шийтгэх, угаал үйлдэх, тангараг тавих, гэр, байшингийн суурь тавихад сайн. Гэр бүрэх, хэрүүл тэмцэл хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:

Энэ өдөр нохой жилтнээ ЭЕРЭГ сайн



### МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН

2.264.962 /69.6%/

ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН

2,161.328 /66.4%/

ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН

862.179 26,5%

### ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

6953 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

206

ЭДГЭРСЭН

6619

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 277,543,285

Эдгэрсэн

Нийт: 248,700,817

Нас барсан

Нийт: 5,394,117

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

# МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН ЦЭРГИЙН НААДАМ ДАХЬ ОРОЛЦООГОО НЭМЭГДҮҮЛЭХИЙГ ЭРМЭЛЗЭЖ БАЙНА



ОХУ-ын хамгаалах санаачилгаар байгуулагддаг Улсын "Цэргийн наадам"-ын анхдугаар хуралдаан өчигдөр цахимаар явагдлаа. Тус хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Беларусь,

Батлан яамны зохион Олон "Цэргийн наадам"-ын хуралдаан өчигдөр цахимаар явагдлаа. Тус хуралд Монгол Улс, ОХУ, БНХАУ, Беларусь,

Узбекистан, Иран, Армени, Вьетнам, Саудын Араб, Алжир, Азербайжан, Казахстан, Шри-Ланк, Пакистан, Венесуэл, Серб, Энэтхэг зэрэг улсын Зэвсэгт хүчний төлөөлөгчид оролцож 2022 онд зохион байгуулагдах тэмцээн,

уралдааны талаар харилцан мэдээлэл солилцсон юм. Хуралдаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнийг төлөөлж ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, Олон Улсын наадмыг зохион байгуулах Үндэсний хорооны

дарга бригадын генерал С.Дашзэвэг болон Сургалтын бодлого зохицуулалтын хэлтсийн Биеийн тамир спортын тасгийн дарга, олон улсын тэмцээний шүүгч хуралдаа Д.Цог-Эрдэнэ, МТГ-ын техникийн хэлтсийн дарга хуралдаа Ц.Төрмөнх

нар оролцлоо.

Хуралын эхэнд олон улсын цэргийн наадмын ерөнхий шүүгч, ОХУ-ын Зэвсэгт хүчний байлдааны бэлтгэлийн ерөнхий газрын дарга хуралдаа генерал И.А.Бувальцев 2022 онд зохион байгуулагдах уралдаан тэмцээний талаар товч мэдээлэл хийв. Цэргийн наадмын хүрээнд нийтдээ 15 улсын нутаг дэвсгэрт, 36 уралдаан, тэмцээн явагдахаас ОХУ-ын нутаг дэвсгэрт 10 тэмцээнийг явуулахаар төлөвлөв. Мөн одоогийн байдлаар цэргийн наадамд нийтдээ 79 баг оролцохоо албан ёсоор мэдэгдсэн бөгөөд Цэргийн наадам 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Красноярск мужийн Ергаки сургалтын төвд нээлтээ хийх юм. Тус наадам "Саянский марш" тэмцээнээр эхэлж 8 дугаар сарын 13-27-ны өдрүүдэд сүүлийн тэмцээнүүд зохион байгуулагдахаар

төлөвлөгдсөн байна.

ОХУ-ын тал 2022 онд уралдаан, тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдад "Цэргийн мэргэжлийн ур чадварын сертификат" мөн оролцсон бүх бие бүрэлдэхүүнд диплом гардуулах аж.

Монгол Улсын Зэвсэгт хүчин "Цэргийн наадам-2022"-ын хүрээнд уламжлал ёсоор "Аравт" морин уралдааныг бие даан, "Цэргийн ралли" уралдааныг ОХУ болон Казахстан Улстай хамтран зохион байгуулах юм.

Түүнчлэн "Танкийн биатлон"-д оролцохоо албан ёсоор мэдэгдсэн бөгөөд энэ тухай ОХУ-ын ЗХЖШ-ын дарга армийн генерал В.Герасимовыг Монгол Улсад айлчлах үеэр албан ёсоор харилцан тохиролцсон бөгөөд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс цэргийн наадам дахь оролцоогоо нэмэгдүүлэхийг эрмэлзэж байна.

## ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ҮР ДҮНТЭЙ БОЛСНЫГ ОНЦЛОН ТЭМДЭГЛЭЛЭЭ



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хошууч генерал О.Энхбаяр АНУ-ын Агаарын хүчний Энэтхэг-Номхон далайн бүсийн командлагч генерал Кеннет С.Вилсбахтай энэ сарын 22-ны өдөр утсаар ярилцаж, өнгөрсөн сард Монгол Улсад зохион байгуулагдсан хоёр орны Агаарын цэргийн командлал хоорондын хоёрдугаар зөвлөлдөх уулзалтын үр

дүнгийн талаар санал солилцлоо. Тус зөвлөлдөх уулзалтаар АНУ-ын Энэтхэг-Номхон далайн бүсийн Агаарын хүчний командлагчийн орлогч хошууч генерал Дэвид Бурги тэргүүтэй төлөөлөгчид Монгол Улсад хүрэлцэн ирж хоёр талын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэгдсэн олон асуудлыг хэлэлцсэн юм.

АНУ-ын Агаарын хүчний Энэтхэг-Номхон далайн бүсийн командлагч генерал Кеннет С.Вилсбах утсаар ярихдаа тус зөвлөлдөх уулзалт үр дүнтэй болсныг онцлон тэмдэглээд цаашид хамтран хэрэгжүүлэх Агаарын цэргийн командлал хоорондын хамтарсан сургалт, дадлага, уулзалтын талаар санал бодлоо хуваалцлаа.

## "МОНГОЛ УЛСЫН БААТАР Т.ДҮҮДЭЙ-100" ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО



Ардын хувьсгалтайгаа нас чацуу Увс аймгийн харьяат Монгол Улсын баатар Түүвэйн Дүүдэйгийн мэндэлсний 100 жилийн ойд зориулан Батлан хамгаалахын сайдын дэргэдэх Иргэний зөвлөл, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуулийн Нийгэм хүмүүнлэгийн тэнхим, Т.Дүүдэй баатрын үр хүүхэд, төрөл төрөгсөд хамтран "Монгол Улсын баатар Т.Дүүдэй-100" эрдэм шинжилгээний хурлыг зохион байгууллаа.

Хурлаар Монгол Улсын баатар цолны уламжлал, шинэчлэлийн зарим асуудал, Т.Дүүдэй баатрын намтар, шинэ баримтууд, 1945 оны Чөлөөлөх дайнд түүний гүйцэтгэсэн үүргийн талаар илтгэл хэлэлцүүлсэн юм. Т.Дүүдэй баатар нь 1945 оны Чөлөөлөх дайны дараа цэргийн албаа үргэлжлүүлэн хааж, 1951 оноос барилгын цэргийн 27 дугаар ангид салбарын захирагчаар ажиллаж байгаад бэлтгэл офицероор халагдан, Улаанбаатар хотын барилга

трест, Увс, Сүхбаатар аймгийн барилгын конторт 10 гаруй жил энх цагийн бүтээн байгуулалтад гар бие оролцож байжээ.

Энэхүү эрдэм шинжилгээний хурлаар эх орныхоо тусгаар тогтнолыг хамгаалахад амь нас, этгэл зүрхээ зориулан тэмцэж ирсэн ахмад үеийнхний дайчин уламжлалын ач холбогдлыг иргэд, хүүхэд залууст сурталчлан таниулж, эх орноо хайрлан хамгаалах, энэрэн тэтгэх үзэл хүмүүжлийг төлөвшүүлэхийг зорьжээ.

### ГЭРЭЛ ЗУРАГ НЭГ АГШИН



Зэвсэгт хүчний төрлийн цэргийн командлалууд болох Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлал, Кибер аюулгүй байдлын цэргийн командлал, Барилга-инженерийн цэргийн удирдах газар "Байлдааны туг"-аа гардан авлаа.

Гэрэл зургийг ахлах ахлагч Г.БАТ-ЭРДЭНЭ



Дарга, ерөнхий редактор, хуралдаан САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ  
Батлан хамгаалах яам  
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС  
"Соёмбо" сонин  
"Дуулга" студи

\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018  
Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)